

ҮНЭТ ЦААСНЫ ҮНЭ ТОГТООСОН ҮНДЭСЛЭЛ

“БДО Аудит” ХХК үнэт цаас гаргагчийн хөрөнгийн болон бизнесийн үнэлгээг хийж гүйцэтгэсэн. Мандал Даатгал ХХК-ийн бизнесийн 25%-ийн хувь оролцоонд ногдох зах зээлийн үнэ цэнэ 7,5 тэрбум төгрөг байх нь үндэслэлтэй гэж үнэлгээний байгууллага дүгнэсэн бөгөөд дээрх үнэлгээний үр дүн болон зах зээлийн өнөөгийн нөхцөл байдлыг харгалзан нэгж хувьцааны үнийг 4,800 төгрөг байхаар тогтоосон байна.

ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

Үнэт цаас гаргагч нь олон нийтэд нээлттэй хүрээнд нэг бүр нь 4,800 төгрөгийн үнэтэй 1,560,754 ширхэг энгийн хувьцаа санал болгох замаар нийт 7,491,619,200 төгрөгийг хөрөнгийн зах зээлээс татан төвлөрүүлнэ. Даатгалын байгууллага нь хувь нийлүүлсэн хөрөнгө/мөнгөн хөрөнгөө нэмэгдүүлэхэд дараах эерэг нөлөөг авчирдаг. Үүнд:

- **Зах зээлд эзлэх байр суурь өсөх** - өндөр дүн бүхий хохирлын эрсдэлийг даатгах чадвартай болж зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлэх боломжтой.
- **Хөрөнгө оруулалтын хэмжээ өсөх** - Даатгалын бизнес хураамжийн орлогоос илүү хөрөнгө оруулалтын орлогоос ашиг хийдэг. Мандал Даатгал хөрөнгө оруулалтын банкны бүтээгдэхүүнд хөрөнгө оруулдаг институцийн хөрөнгө оруулагч болох юм.

Дээрх 2 шалтгаанаар компанийн ашиг өсөж хөрөнгө оруулагчид ач тусыг нь хүртэнэ.

ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНД ОРОЛЦОХ

Хөрөнгө оруулагчид үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд дараах зааврын дагуу оролцоно.



АРИЛЖААНЫ ДАНС НЭЭЛГЭХ

Брокерын компанид өөрийн биеэр үнэт цаасны данс нээлгэнэ. /Иргэний үнэмлэх, 5,000 төгрөгийн хамт/



ЗАХИАЛГА ӨГӨХ

Өөрийн брокерт хувьцаа худалдан авах захиалга өгнө.



МӨНГӨ БАЙРШУУЛАХ

Өөрийн үнэт цаасны дансанд дараах зааврын дагуу мөнгөн дүнг арилжааны шимтгэлийн хамт байршуулна.

Хөрөнгө оруулагч та хувьцаа худалдан авах мөнгөө захиалга хаах хугацаанаас 3 цагийн өмнө байршуулсан байх ёстойг анхаарна уу.

- Хувьцааны захиалга өгөх сүүлийн өдөр - 2018/09/18, 12:00 цаг хүртэл
- Арилжааны данс нээх сүүлийн өдөр - 2018/09/16

| | |
|------------------|------------------------------------|
| Дансны нэр: | Харилцагчийн нэр |
| Дансны дугаар: | 0120 ●●●● ●●●● /Брокероос авах/ |
| Банкны нэр: | Арилжааны Төлбөр Тооцоо |
| Гүйлгээний утга: | Нэр, регистр, Мандал IPO |

Мандал Даатгал ХК

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот 14230, Сүхбаатар дүүрэг, Нарны зам 87, НСКБ Билдинг, 2 давхар

ipo.mandal.mn
7575 2000

Голомт Капитал ҮЦК ХХК

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 24, 1-р хороо, Parkplace оффис, 4 давхар

golomtcapital.com
7012 1530

Андеррайтер:

**Golomt
Capital**

Үнэт цаас гаргагч:



IPO

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

| | |
|--|------------------------------|
| Нийт гаргасан хувьцааны тоо | 6,243,016 ширхэг |
| Нийтэд санал болгох хувьцааны тоо | 1,560,754 ширхэг |
| Нийтэд санал болгох хувь | 25.00% |
| Нийтэд санал болгох үнэ | 4,800 төгрөг |
| Олон нийтээс татан төвлөрүүлэх дүн | 7,491,619,200 төгрөг |
| Хувьцааг арилжаалах арга | Тогтоосон үнийн арга |
| Захиалга авах хугацаа: | 2018/09/04-2018/09/18 |

КОМПАНИЙН ТУХАЙ

Мандал Даатгал нь анх 2011 онд “Мандал генерал даатгал” нэртэйгээр ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 15 дахь компани болон үүсгэн байгуулагдаж байсан билээ. 2018 оны 2-р улирлын байдлаар Мандал Даатгал нь нийт 46 мянга гаруй хувь хүн болон албан байгууллагын эрсдэлийг даатгаж, хураамжийн орлогоор зах зээлийн 21 хувийг эзэлсэн салбарын тэргүүлэгч даатгалын компани юм.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2018 оны 2-р улирлын байдлаар



Цэвэр ашиг

2.1 тэрбум төгрөг



Даатгуулагчдын тоо

45,997

Нийт хураамжийн орлого, сая төгрөгөөр

| | |
|--------|--------|
| 2018Q2 | 17,246 |
| 2017 | 22,533 |
| 2016 | 13,092 |
| 2015 | 9,184 |

Зах зээлд эзлэх хувь

| | |
|--------|-----|
| 2018Q2 | 21% |
| 2017 | 16% |
| 2016 | 12% |
| 2015 | 8% |

Мөнгөн хөрөнгө, сая төгрөгөөр

| | |
|--------|--------|
| 2018Q2 | 15,102 |
| 2017 | 11,035 |
| 2016 | 6,977 |
| 2015 | 6,194 |

Нийт актив, сая төгрөгөөр


| | |
|--------|--------|
| 2018Q2 | 29,323 |
| 2017 | 21,472 |
| 2016 | 17,309 |
| 2015 | 9,797 |

ДААТГАЛЫН САЛБАРЫН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2018 оны 2-р улирлын байдлаар


Нийт хураамжийн орлого, тэрбум төгрөгөөр

| | |
|--------|-----|
| 2018Q2 | 83 |
| 2017 | 144 |
| 2016 | 115 |
| 2015 | 114 |




Цэвэр ашиг, тэрбум төгрөгөөр

| | |
|--------|-----|
| 2018Q2 | 4.0 |
| 2017 | 7.9 |
| 2016 | 7.4 |
| 2015 | 4.8 |



Нийт актив, тэрбум төгрөгөөр

| | |
|--------|-----|
| 2018Q2 | 227 |
| 2017 | 194 |
| 2016 | 173 |
| 2015 | 147 |



ДААТГАЛЫН САЛБАРЫН ИРЭЭДҮЙН БОЛОМЖ

Бид даатгалын салбарын ирээдүйн боломжийг дараах аргачлалаар тооцооллоо.

1 Салбарын орлого
144 тэрбум → 870 тэрбум

2 Даатгалын компаниудын хөрөнгө
244 тэрбум → 2.7 их наяд

Нэгдүгээрт, ДНБ-д эзлэх даатгалын салбарын хураамжийн орлогын хувь буюу даатгалын нэвтрэлтийн түвшин хөгжиж буй орнуудын хэмжээнд хүрэхэд, салбарын хураамжийн орлого **870 тэрбум төгрөгөөр** хэмжигдэнэ.

Хоёрдугаарт, даатгалын салбарын хөгжлийг даатгалын компаниудын хөрөнгийн хэмжээг санхүүгийн зах зээлд эзлэх хувиар илэрхийлдэг. Гэтэл Монгол Улсын даатгалын салбар нь санхүүгийн зах зээлийн 0.8 хувийг эзэлж байгаа бөгөөд дэлхийн дундаж үзүүлэлт 8.6 хувьтай байдаг. Монголын даатгалын салбарын үзүүлэлт энэ түвшинд хүрэхэд, даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ **2.7 их наяд төгрөгт** хүрч, **10 дахин өсөх** боломжтой.

ДУНД ХУГАЦААНЫ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ

Санхүүгийн голлох үзүүлэлтүүд, тэрбум төгрөг

Нийт хураамжийн орлого

| | |
|------|------|
| 2017 | 22.5 |
| 2020 | 33.5 |
| 2022 | 45 |

Нийт хөрөнгө

| | |
|------|----|
| 2017 | 21 |
| 2020 | 44 |
| 2022 | 71 |

Цэвэр ашиг

| | |
|------|-----|
| 2017 | 1 |
| 2020 | 5.5 |
| 2022 | 11 |